

Та хүнд хэцүү нөхцөлд байгаа бөгөөд юу хийх ёстойгоо мэдэхгүй байна уу?



ТАНЫ ХӨДӨЛМӨРИЙГ МӨЛЖИХИЙГ БҮҮ ЗӨВШӨӨР!

ТА БҮГД НАЙРАМДАХ ЧЕХ УЛСЫН ИРГЭН ЭСВЭЛ ГАДААДЫН ИРГЭН БАЙХААС ҮЛ ХАМААРАН ХӨДӨЛМӨРИЙН ХУУЛЬ ХҮН БҮРД ТЭГШ ҮЙЛЧИЛДЭГ.

- » Таны цалин хөлсийг өгөхгүй байна уу?
- » Таны ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн гэрээний тань эх хувийг танд өгөхгүй байна уу?
- » Та цалингийн хамгийн доод/ батлагдсан хэмжээнээс бага цалин авч байна уу?
- » Ажил олгогч тань таныг долоо хоногт 40 цагаас эсвэл өдөрт 12 цагаас илүү цагаар ажиллуулж байна уу?
- » Та бие махбодын эсвэл бэлгийн хүчирхийлэлд эсвэл заналхийлэлд өртөж байна уу?
- » Та эрүүл ахуй, эрүүл мэнд эсвэл аюулгүй байдлыг хангаагүй нөхцөлд хөдөлмөр эрхэлж байна уу?
- » Таны бичиг баримтыг хурааж авсан эсвэл чөлөөтэй явах эрхийг тань хязгаарлаж байна уу?

Та дарамтад орсон байна уу? Та Бүгд Найрамдах Чех Улсад хууль бусаар, бичиг баримтгүй оршин суудаг байсан ч гэсэн тусламж, хамгаалалт хүсэхээс бүү эмээгээрэй.

- » Ойлгохгүй байгаа бичиг баримтандаа гарын үсэг бүү зураарай (жишээ нь. таныг төлөөлөх итгэмжлэл, торгууль төлөх зөвшөөрөл, цалингийн суутгал гэх мэт)!
- » Цалингийн цэсээ авах хүсэлт үргэлжгаргаж, үүнийгээ хадгалж байгаарай!
- » Ажил олгогч тань таны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалыг төлж буй эсэхэд хяналт тавьж байгаарай!

Хөдөлмөрийн мөлжлөг нь гэмт хэрэг бөгөөд мөлжигч этгээд ноцтой шийтгэл хүлээдэг! НЭН ДАРУЙ өөрийгөө хамгаалаарай!



Ажил олгогчийг шалгуулах талаарх гомдлыг **Мужийн хөдөлмөр эрхлэлтийн хянан шалгалтын газарт** гаргаарай



Мужийн хөдөлмөр эрхлэлтийн хянан шалгалтын газраас хөдөлмөрийн харилцаа, тусламж дэмжлэгийн талаар олж мэдээрэй



Хууль эрх зүйн эсвэл нийгмийн асуудлаар өөрийн хэл дээрх үнэ төлбөргүй тусламжийг олж аваарай – **Байгууллага, институт болон мэргэжилтнүүдийн тухай лавлах**



Гадаадын иргэдэд мэдээлэл өгөх зориулалттай **Smart Migration** гар утасны аппликейшныг татаж аваарай